



## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Гаалийн тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай 2021 оны 11  
дүгээр сарын 12-ны өдрийн хууль

Дагаж мөрдөх огноо:

2022 оны 01 дүгээр сарын 01

Албан тушаалын тодорхойлолтыг  
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Гаалийн ерөнхий газар

Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх  
хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн  
дарга

Ахлах түшмэл, ТТ-3

Ажлын цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

14193 Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг,  
8 дугаар хороо, Их тойруу 81-1

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Албан ажлын онцгой нөхцөлд  
хамаарна

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдогчдын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээлэл хүлээн авах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, онилж, илрүүлэх ажиллагааг удирдан зохион байгуулж, Үндэсний хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан гаалийн байгууллагын хариуцах ажлын хэрэгжилтийг хангаж, Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодыг мэргэжил, арга зүйн удирдлага чиглэлээр хангах, хариуцсан албан хаагчдыг сургалтад хамруулах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх зэрэг үндэстэн дамнасан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр, стандарт, дотоодын хууль, тогтоомж, үндэсний хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хангах, тайлагнах ажлыг удирдан зохион байгуулах;
2. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис, бэлэн мөнгө, валютын хууль бус эргэлт, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хойшлуулшгүй ажиллагаа, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, урьдчилан сэргийлэхтэй холбоотой асуудлаар мэргэжил, арга зүйн удирдамж чиглэлээр хангах, үүрэг даалгавар, зөвлөмж хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг удирдан зохион байгуулах;
3. Дэлхийн гаалийн байгууллага, бус нутгийн хамтын ажиллагааны байгууллага, дотоодын хууль хяналтын болон бусад байгууллага, иргэдээс хүлээн авсан хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис, бэлэн мөнгө, валют, стратегийн болон хоёрдмол зориулалттай барааг гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотой гомдол, мэдээлэл, санал хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, мэдээллийн сан үүсгэх, дүн шинжилгээ хийх, мэдээлэл солилцох, шийдвэрлэх ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах;
4. Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцох.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах- Т, Гүйцэтгэх - Г Хянах- Х Шийдвэрлэх- Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлыг удирдан зохион байгуулах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Ш, Х
	2. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний хангах ажлыг удирдан зохион байгуулах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Ш, Х
	3. НҮБ-ын Аюулгүй Зөвлөлийн 1540 дугаар тогтоол, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх үндэсний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг удирдан зохион байгуулах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Ш, Х
	4. Монгол банкны мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүний үүрэг	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Ш, Х, Г



	гүйцэтгэж, гаалийн байгууллагын мөнгө угаахтай тэмцэх ФАТФ-ын зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах;		
	5. Харьяа гаалийн газар, хороодын хар тамхи, мансууруулах бодис болон хууль бус бэлэн мөнгө, валютыг илрүүлэх хяналт шалгалтын тоног төхөөрөмжийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, судалгаа хийх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, удирдлагад танилцуулах.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Ш, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд хийгдэх хойшлуулшгүй ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Ш, Х
	2. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн хүрээнд хийгдэх ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Ш, Х
	3. Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис, бэлэн мөнгө, валютын хууль бус эргэлт, мөнгө угаах гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох шуурхай ажиллагаа, арга хэмжээг удирдан зохион байгуулж, албан хаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Ш, Х, Г
	4. Албан хаагчдыг хар тамхи, мансууруулах бодис, бэлэн мөнгө, валютын хууль бус эргэлт, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, стратегийн болон хоёрдмол зориулалттай барааны хяналтыг хэрэгжүүлэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил илрүүлэх чиглэлээр мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Ш, Х, Г
	5. Хар тамхи, мансууруулах бодис, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, стратегийн болон хоёрдмол зориулалттай бараатай холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг гаалийн байгууллага, хамтын ажиллагаатай төрийн болон төрийн бус байгууллага, гаалийн харилцаанд оролцож буй аж ахуйн	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Ш, Х, Г



	нэгжүүдийг хамруулан зохион байгуулах.		
3 дугаар зорилтын хүрээнд	1. Хар тамхи, мансууруулах бодис, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, стратегийн болон хоёрдмол зориулалттай бараатай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэн төрөлжүүлж, мэдээллийн сан үүсгэх ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;	Мэдээллийн санг бүрдүүлсэн байдал	Х, Ш
	2. Хар тамхи, мансууруулах бодис, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, стратегийн болон хоёрдмол зориулалттай бараатай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох, судалгаа дүн шинжилгээ хийх ажлыг удирдан зохион байгуулах;	Дүн шинжилгээ судалгааны тоо	Х, Ш
	3. Хар тамхи, мансууруулах бодис, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, стратегийн болон хоёрдмол зориулалттай бараатай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавих;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Х, Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Байгууллагын чиг үүрэг, стратеги төлөвлөгөөтэй уялдуулан нэгжийн үйл ажиллагаанд эрсдэл тооцож, төлөвлөгөөний төслийг боловсруулан, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө нь байгууллагын стратеги, гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдсан байна	Х, Ш, Г
	2. Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, ажил үүргийн хуваарийг гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан жил бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүр гарган, хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааг оновчтой удирдан зохион байгуулах;	Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд үйл ажил үүрэг давхцахгүй, орхигдохгүй байхаар төлөвлөгдсөн байна	Х, Ш, Г
	3. Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодыг хар тамхи, мөнгө угаахтай холбогдох асуудлаар удирдамж чиглэлээр хангаж, үүрэг даалгавар, зөвлөгөө	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Х, Ш



	өгөх, хяналт тавих, сургалт зохион байгуулах;		
	4. Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, манлайллыг удирдлага болгон ажиллах;	Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэсэн байна	Г, Х
	5. Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн баримт бичгийн төсөл боловсруулах, архивын нэгж бүрдүүлэх ажилд хяналт тавих;	Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн байна	Х
	6. Нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой програм хангамжийн хөгжүүлэлт, мэдээллийн сангийн баяжуулалт хийх ажлыг удирдан зохион байгуулах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Х, Ш
	7. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, олон нийтийг хамруулсан арга хэмжээ зохион байгуулах, оролцох, хамт олныг хамруулах;	Хамт олныг хамруулан зохион байгуулсан арга хэмжээ, хурал, цуглааны тоо, үр дүн	Ш, Г

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> <li>- Менежмент ба удирдахуй (0413),</li> <li>- худалдаа (0416),</li> <li>- эрх зүй (0421),</li> <li>- аюулгүй байдлыг хангах (103),</li> <li>- хими (0531).</li> </ul>	
Мэргэшил	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх.	
Туршлага	Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>- нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах;</li> <li>- санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх;</li> <li>- нэгжийн албан хаагчдын ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах;</li> <li>- байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;</li> <li>- албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- нэн тэргүүний ажлыг тодорхойлоход чиглэл, зааварчилгаа өгөх;</li> <li>- цаг үеийн шинж чанартай, гэнэтийн үйл явдлыг зөв, оновчтой шийдвэрлэх;</li> </ul>



		- бусад.
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- өгөгдөл/мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах, бүтэц, чиг үүргийн шинжилгээ хийх;</li> <li>- мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдогчдын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажлыг боловсронгуй болгох асуудлаар бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмжийн төсөл боловсруулах;</li> <li>- тулгамдаж буй асуудалд шийдэл олох, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар дүн шинжилгээ хийх;</li> </ul>
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- албан тушаалын чиг үүргийн дагуу хариуцах ажлыг хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;</li> <li>- сэтгэн бодох, анализ хийх, хөрвөх чадвартай байх;</li> <li>- шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх, гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах;</li> <li>- мэдээлэл/мэдлэгийг үнэлэн, мэдээллийг түргэн, шуурхай, үр дүнтэй нягтлан судалж, нэмэлт мэдээлэл шаардлагатай эсэхийг тодорхойлох;</li> <li>- асуудал, бэрхшээлийг урьдчилан тооцож, сэргийлэх арга хэмжээ авах;</li> </ul>
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> <li>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;</li> <li>- байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх;</li> <li>- хувийн зохион байгуулалт, ёс зүйгээр бусдыг манлайлан, үлгэр дууриалал үзүүлэх;</li> <li>- ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, зөвлөмж өгөх, чиглүүлэх зэргээр үлгэрлэн, дэмжиж ажиллах;</li> <li>- эерэг дулаан, нөхөрсөг уур амьсгалыг бий болгох;</li> <li>- нэгжийн үйл ажиллагаанд шинэлэг санаа үйлчилгээг нэвтрүүлэх, чиглүүлэх;</li> <li>- албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих;</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах;</li> <li>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;</li> <li>- мэдээллийн технологийн хэрэглээний мэдлэгтэй байх;</li> <li>- албан хаагчдад ажлын байран дээр тасралтгүй сурч хөгжих боломжийг бүрдүүлэх;</li> <li>- төрийн албан хаагчийн болон гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээ, үйлчилгээний стандарт, сахилгын тусгай дүрмийг чанд сахин ажиллах, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;</li> </ul>



	<ul style="list-style-type: none"> <li>- монгол хэл бичгийн мэдлэгийн төвшин нь албан ажлын шаардлагыг хангасан;</li> <li>- өөрийн мэдлэг, чадвар, өөрт байгаа мэдээллийг баг, хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах;</li> <li>- багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах;</li> <li>- харилцааны орчин үеийн арга хэлбэрийг ашиглан, мэдээллийг хүргэх, түгээх.</li> </ul>
--	---

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:  
Зөрчилтэй тэмцэх, аюулгүй байдлын газрын дарга


Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

- гаалийн улсын ахлах байцаагч 1
  - Гаалийн улсын байцаагч 5
- Нийт:6

Бусад харилцах субъект:

- Төрийн болон турийн бус байгууллагын холбогдох ажилтан;
- Иргэн, хуулийн этгээд;
- Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хорооны дарга, албаны дарга, салбарын эрхлэгч, гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч, бусад ажилтан.

#### V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</u>
<p><u>Албан тушаал:</u> ХУУЛИЙН ХЭЛТЭЙН ДАРГА  .....Ч.ТАМИРАА (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2023 оны 4 сарын 11-ны өдөр</p>	<p><u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: <b>23 03 09</b> Дугаар: <b>061</b></p>

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр:  
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
Шийдвэрийн огноо:.....  
Дугаар:.....  
(тамга/тэмдэг)  
ДАРГА:.....  
  
.....Р.ОТГОНЖАРГАЛ  
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)  
2023 оны 04 дугаар сарын 12-ны өдөр

